



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/59

Булган сум


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дэлхийн Алтаргана 2024” наадмын үйл ажиллагааг сурталчлах, хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Буриад улсаас ирсэн зочид төлөөлөгчдийн байр, хоол, бусад зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Дэлхийн Алтаргана 2024” төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010098

Аймгийн Засаг даргын 2024 оны 02
дугаар сарын 07-ны өдрийн 4/59 дугаар
захирамжийн хавсралт



**“АЛТАРГАНА 2024” ОЛОН УЛСЫН НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УУЛЗАЛТ,
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТӨСӨВ.**

№	Шаардагдах зардал	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.Байр зардал				
1.	Буудал /2 хоног/	50	80,000	8,000,000
	Нийт			8,000,000
2.Бусад зардал				
1.	Ус, ундаа	400ш	5,000	2,000,000
	Нийт			2,000,000
	Нийт дүн			10,000,000